



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 4 дүгээр  
сарын 18-ны өдөр

Дугаар 101


Улаанбаатар  
хот

“Авто зогсоолын цогцолбор”  
төсөл хэрэгжүүлэх тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26.2.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тавантолгой ордоос улс хооронд худалдаалах нүүрсний тээвэрлэлтийг хилээр саадгүй нэвтрүүлэх, байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл болон авто замын ачаалал, осол, зөрчлийг бууруулах, жолооч (тээвэрлэгч) нарын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэр дэх улсын хилийн зурвасын хавсралтад заасан хилийн зааг, эргэлтийн цэгийн солбицол, талбай бүхий газарт “Авто зогсоолын цогцолбор” төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Авто зогсоолын цогцолбор” төслийг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шаардлага хангасан хуулийн этгээдтэй газар ашиглуулах болон үйл ажиллагаа явуулах гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд


У.ХҮРЭЛСҮХ

Зам, тээврийн хөгжлийн сайд

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Барилга, хот байгуулалтын сайд

Х.БАДЕЛХАН



Засгийн газрын 2018 оны 101 дугаар  
тогтоолын хавсралт

“АВТО ЗОГСООЛЫН ЦОГЦОЛБОР” ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ УЛСЫН  
ХИЛИЙН ЗУРВАС ДАХЬ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ,  
ЭРГЭЛТИЙН ЦЭГИЙН СОЛБИЦОЛ,  
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

№	Уртраг			Өргөрөг			Талбайн хэмжээ /га/	Зориулалт	Байршил
	1	2	3	4	5	6			
1	42	29	23.48	107	33	36.59	48	Авто зогсоолын цогцолбор	Өмнөговь аймаг, Ханбогд сум, Хайрхан баг
2	42	30	24.73	107	33	29.06			
3	42	30	25.34	107	33	42.4			
4	42	29	23.68	107	33	45.31			